

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

**НЭВТРҮҮЛЭГЧ, ХӨТЛӨГЧИЙН ХЭЛ ЯРИАНЫ ЧАДВАРЫГ
САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛД**

Б.Алимаа*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үг: Нэвтрүүлэгч хөтлөгчийн хэл хэллэг, зөв дуудлага, амьсгаа, зогсолт, өргөлт, сураг занги, дуулгах мэдээ

Эртний монгол хаадын үед дуулгах мэдээ гэж байжээ. Мэдээ дуулгадаггүй хүмүүс нь өнөөдрийн нэвтрүүлэгч хөтлөгчтэй адилаар үүрэг гүйцэтгэдэг хүмүүс байсан. Тиймээс нэвтрүүлэгч хөтлөгчийн ажил уул нь хаадын баруун гарын түшмэлийн ажил байсан гэж Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн, нэрт нэвтрүүлэгч Г.Чулуунбат гуай хэлсэн байдаг. Энэ нь нэвтрүүлэгч хөтлөгчийн ажил бол нарийн мэргэжил, маш чухал ажил гэдгийг уран зүйрэллээр илэрхийлсэн хэрэг юм. Нэвтрүүлэгч хөтлөгч бол “дуу хоолойн жүжигчин” гэсэн хэллэг ч байдаг нь үүнтэй холбоотой юм. Энэ нь нэвтрүүлэгч хөтлөгчийн ажилд ур авьяас, мэргэжил боловсрол зайлшгүй шаардагддаг гэснийг харуулж байна. Тэгвэл сонин мэдээ, сураг занги, тусгай нэвтрүүлэг үзэгч сонсогчийн сэтгэлд буутал хүргэж чаддаг нэвтрүүлэгч хөтлөгчид чухам юу хамгийн чухал байдаг вэ? Яриангүй үүнд тухайн хүний дуу хоолой зэрэг физиологийн нөхцлөөс авахуулаад мэдлэг, боловсрол гэх мэтчилэн олон талын нөхцөл шаардагдах нь гарцаагүй. Гэхдээ энэ бүхнийг

ширхэглэн тоочих биш, зөвхөн нэвтрүүлэгч хөтлөгчийн хэл хэллэгт шууд холбогдох зөв дуудлага, амьсгаа, зогсолт, өргөлт мэтийн хэдхэн тодорхой асуудлын хүрээнд тогтож ярихыг зорилоо.

Нэг. Зөв дуудлага бол нэвтрүүлэгч, хөтлөгчийн хэл хэллэгийн заавал биелүүлэх үндсэн шаардлага мөн.

Хэл бол хүмүүсийн харилцааны хамгийн чухал хэрэглүүр бөгөөд энэ нь ярианы болон бичгийн гэсэн хоёр хэлбэртэй. Энэ хоёр хэлбэр нь хүний санаа бодлыг дамжуулах үүрэг чадамжаараа адилхан боловч илрэх хэлбэр болон бусдад хүргэгдэх арга замын хувьд тун их ялгаатай. Ярианы хэл нь дуу авиагаар хүмүүсийн сонорт, бичгийн хэл нь тусгай болзолт тэмдэгтээр хүмүүсийн хараанд тус тус хүрдэг. Гэхдээ ярианы хэл бол анхдагч бөгөөд шууд, бичгийн хэл бол хоёрдогч бөгөөд дам байдаг шинжтэй. Ярианы хэл нь бичгийн хэлийнхээ суурь мөртлөө бичгийн хэл нь ярианы хэлний үйлдлийг өргөтгөдөг онцлогтой. Тухайлбал, үсэг бичигтэй болсноор хүн төрөлхтөн хуримтлуулсан баялаг туршлагаа ном бичгийн хэлбэрээр хойч үедээ уламжлан үлдээж, шинжлэх ухаан, соёл боловсролоо хөгжүүлэн, нийгмийн дэвшил хөгжлийн замаар замнаж ирсэн байдаг. Шинжлэх ухаан хөгжөөд хүний

үг яриаг төрөл бүрийн бааз төхөөрөмжөөр дамжуулах буюу хадгалах болсон явдал нь үсэг бичгийн үнэ цэнийг өчүүхэн ч бууруулсангүй, харин хэвлэл мэдээлэл, радио телевиз мэт инхэвчлэн мэдээллийн хэрэгслийг улам эрчимтэй хөгжүүлж байгааг бид бүхэн андалгүй мэдэж байгаа. Энэ нь нэвтрүүлэгч хөтлөгчийн үүрэг хариуцлага улам өндөр түвшинд шаардагдах болсныг харуулж байна¹. Иймээс маш их ур чадвар шаардагдах ажил юм. Авьяасын урьдач нөхцөл нь байгалиас заяасан ер бусын чадвар буюу сэтгэн бодох мэдрэлийн үйл ажиллагаа, нэгдэх буюу хоёр дахь дохионы системийг харилцан нөлөөллийн хөгжил, мэдрэлийн үйл ажиллагааны хөдөлгөөн, харилцан шилжилт, ой тогтоолт, тунгаан бодох, хурдан шуурхай тусгах чадварын өсөлт байдаг. Авьяасыг хөгжүүлэх, боловсронгуй болгох гол үндэс бол уран бүтээлчийн уйгагүй хөдөлмөр юм. Нэвтрүүлэгч, хөтлөгчийн байнгын эрэл хайгуул, хичээл зүтгэлээс эхэлдэг.

Хэлний хамгийн бага нэгж нь авиа, дохионы нэгж нь үг, харилцааны үндсэн нэгж нь өгүүлбэр. Хүмүүс харилцахдаа үг өгүүлбэрийг бүхлээр нь хүлээн авч ухаарахаас биш салангид авиагаар нь ойлгодоггүй. Гэхдээ ямар нэгэн авиаг буруу дуудвал үзэгч сонсогч тэр доор нь авианы гаж бурууг тэр бүр анзаарахгүй өнгөрдөг учраас утгыг нь шууд хүлээн авч чадахгүй болно. Зөв бичлэгийн дүрэм горимоор бичигдсэн бөгөөд хэл найрууллагын шаардлагыг хангасан үг өгүүлбэрийг зөв уншлагын дүрмийн дагуу зөв тэгш бөгөөд төгөлдөр илтгэх явдал нь нэвтрүүлэгч хөтлөгчийн тухайлсан ажлын үүрэг. Энэхүү үүргийг сайтар гүйцэтгэхэд зөв дуудлага ер нь нэвтрүүлэгч хөтлөгчийн хэл

хэллэгт заавал шаардагдах үндсэн нөхцөл болдог.

Хятад хэлний нэвтрүүлэгч хөтлөгчид нийтлэг хэл (普通话), монгол хэлний нэвтрүүлэгч хөтлөгчид баримжаа авианы шаардлага тус тус тавьдаг нь яг нэвтрүүлэгч хөтлөгчийн тухайлсан ажлын үүрэг болон хэл хэллэгийн бүрэлдүүлбээс зохих үндсэн нөхцөл шаардлагаас тогтоогдсон юм. Монгол хэлний тодорхой жишээн дээр ярихад, уруулын эгшиг [ɔ] [ʊ] хоёр болон [o] [u] хоёрыг тод ялгах, амьсгалын түрэлттэй эсэхээр эсэргүүцэлдсэн зэргийг хутгалгүй зөв дуудах явдал тун чухал байдаг.

Хоёр. Амьсгаа бол нэвтрүүлэгч хөтлөгчийн хэл хэллэгийн дутагдаж болшгүй дасгал боловсрол мөн.

Амьсгааг цээжний амьсгаа, өрцний амьсгаа, хэвлийн амьсгаа хэмээн гурав ангилдаг. Зөв боловсон ярихад зөвхөн зарим авиа (үг)-ийг цэвэр дүрмийн дагуу дуудсанаар шаардлага хангагдах биш, үг бүхнийг яруу тод хэлж, амьсгалаа зөв хуваарилан түгдрэлгүй ярих нь маш чухал байдаг. Ийнхүү амьсгалын давтамжийг ихэсгэх, түүнийг зөв хуваарилахад түргэн хэллэг дутагдаж болшгүй чухал дасгал болдог. Монгол хэлэнд түргэн хэллэгийг эзэмшихэд тусгай зориулагдсан “гучин хоёр цагаан лонх”, “сайн эрийн гучин хоёр хул” тоолох мэтийн үг хэлний тоглоомууд байдаг. Энэ бүхнийг нэг л амьсгаанд тоолох нь амьсгал уртасгахын зэрэгцээ түгдрэлгүй шууд яруу тод ярих чадварыг дээшлүүлэхэд маш их тус болдог. Энэ нь үг яриаг яруу тод хэлэх чадварыг бүр илүү дуучин, жүжигчин, нэвтрүүлэгч хөтлөгч нарт нэн хэрэгтэй дасгал боловсрол болох нь мэдээж. Жороо хэллэг, хэл зүгшрүүлэх үг нь нэвтрүүлэгч хөтлөгчийн амьсгааг сайжруулахад хамгийн чухал дасгал болж эрч энерги өгдгийг онцлон

дурдууштай. Жишээлбэл, “Эргэн дээр элээ хэрээ галуу гурав эрүү амаа долоолцоно”, “тал дээр тавин таван тарган тарвага байна, энэ тавин таван тарган тарвагыг тавин таван тарган тарвага гэхгүй, өөр ямар тавин таван тарган тарвага тал дээрх тавин таван тарган тарвага гэх вэ” гэх мэтийн хэллэгүүд бол яг ийм хэрэгцээтэй зүйл юм. Ялангуяа “ийм сайхан гөлгөр гөлчөр, гөлтгөр балтгар, хотгор гүдгэр, хонхор гүнхэр газрыг, гөлгөр гөлчөр, гөлтгөр балтгар, хотгор гүдгэр, хонхор гүнхэр газар гэх үгүй, өөр ямар янзын гөлгөр гөлчөр, хүлтгэр балтгар, хотгор гүдгэр, хонхор гүнхэр газрыг, гөлгөр гөлчөр, хүлтгэр балтгар, хотгор гүдгэр, хонхор гүнхэр газар гэх юм бэ” гэдэг түргэн хэллэг байдаг бөгөөд үүнийг нэлээд бүрэн хэмжээнд амьсгааны хэмнэл, үгийн тоо, хурдцын тохируулалт тэнцсэн гоц хэллэг гэж хүмүүс үздэг².

Нэвтрүүлэгчийн соёлын түвшин, мэргэжлийн суурь бүгд чухал. Жирийн хүмүүс хэв боловсрол гэдэг үгийг ухамсартай, ухамсаргүйгээр холбож сэтгэдэг. Бидний судалгаа хийх явцад ойлгосноор, зарим нэвтрүүлэгч хөтлөгч хэв боловсрол муутай байна гэж зэмэлдгийн шалтгааныг лавлавал дийлэнх нь “ердийн мэдлэгийн алдаа”, “ташаарсан үсэг олон”, “тун өөриймсөг” байгаа бол хөтлөгч хүний соёлын хэв боловсрол өндөр биш байгаагийн илрэл мөн гэж үзэж байна. Харин нэлээд

ноцтой асуудал бол мөн л нэвтрүүлэгч хөтлөгч хүний шинжлэх ухааны соёлын хэв боловсрол өндөр биш, суурь мэдлэг нимгэн зэрэг асуудал оршино.

Гурав. Зогсолт өргөлт бол нэвтрүүлэгч хөтлөгчийн хэл хэллэгийн маш чухал ур чадвар мөн.

Зогсолтыг агуулгаар нь утгын зогсолт, үгийн зогсолт, хүний анхаарлыг татах зогсолт гэмээн гурав ангилна. Нэг мэдээ яриад нэг зогсож байх нь дуу хоолойгоор тур зогсож, хоёр нэвтрүүлэгч мэдээ уншихад, эмэгтэй нэвтрүүлэгч уншиж дуусвал эрэгтэй нэвтрүүлэгч тосож авч байх нь дуу хоолойн өгөлт авалт юм. Мэдээг уншихад гурван

үг нэг секундэд багтдаг. Дахивал бас мэдээний том жижиг гарчгийг хүртэл дуу хоолойгоор ялгаж унших ёстой, бичгийн хэлийг ярианы хэлний намбатай болгохын тулд “ба, болон” гэх мэтийн холбоос үгийг орхиж, шууд амьсгааны зогсолтоор ялгаж өгдөг.

Зогсолтыг хурдаар нь удаан, дунд, хурдан гэж гурав ангилдаг.

“Удаан зогсолт” нь баярлах, гомдох, цочирдох зэрэг сэтгэлийн хөдөлгөөнийг илтгэдэг бол “дунд зогсолт” нь голдуу уран илтгэгч, радио телевизийн нэвтрүүлэгч хөтлөгч, улстөрч зэрэг хүмүүсийн уран илтгэл хийхэд илэрдэг. Хэлэх гэсэн гол санааныхаа өмнө дунд зогсолт хийх нь чухал ач холбогдолтой. “Хурдан зогсолт” нь цаг хугацааны хувьд хором ч хүрэхгүй боловч үгийн утгыг огт өөр болгоно. Гадаадынхны

«

Зогсолтыг хурдаар нь удаан, дунд, хурдан гэж гурав ангилдаг. “Удаан зогсолт” нь баярлах, гомдох, цочирдох зэрэг сэтгэлийн хөдөлгөөнийг илтгэдэг бол “дунд зогсолт” нь голдуу уран илтгэгч, радио телевизийн нэвтрүүлэгч хөтлөгч, улстөрч зэрэг хүмүүсийн уран илтгэл хийхэд илэрдэг. Хэлэх гэсэн гол санааныхаа өмнө дунд зогсолт хийх нь чухал ач холбогдолтой

»

судалснаар зар сурталчилгааг энгийн болон жүжиглэсэн гэж хоёр ангилдаг байна. Ямар нэгэн таваарын тухай зарыг жүжигчин маш богинохон хугацаанд үзэгчдэд жүжиглэж танилцуулахад 50-60 хувь нь борлуулалтгүй үлддэг. Учир нь, хүмүүсийн анхаарал жүжиг тоглож байгаа гол дүр дээр төвлөрөөд таваарыг нь анзаардаггүй. Гэтэл нэвтрүүлэгч хөтлөгч хурдан буюу дунд зогсолтыг эвлэгхэн хэрэглэж, утгыг алдагдуулгүйгээр зар мэдээ уншихад таваарын борлуулалт 90 хувиас дээш хүрэх магадлалтай. Энэ нь нэвтрүүлэгч хөтлөгчийн хэл хэллэгийн айзам зогсолт маш чухал гэдгийг харуулж байна.

Нэвтрүүлэгч хөтлөгчийн хэл хэллэгт үг өгүүлбэрийн өргөлт онцгой чухал үйлдэл үзүүлдэг. Олны мэдээжээр тухайн үгийг бүтээж байгаа үеийн дотроос аль хүчтэй хэлэгддэг үеийг үгийн өргөлтөт үе гэдэг. Өөрөөр хэлбэл, үгийн өргөлт тэр үеийн дээр оногдож байна гэсэн үг. Ер нь дэлхийн олон хэлэнд хүчлэх өргөлт буюу уянгалах өргөлт гэж байдаг. Монгол хэлний үгийн өргөлтийн талаар олон санал байдаг боловч нэгдүгээр үе дээр тогтмол байдаг хүчлэх өргөлт хэмээн үздэг. Хүчлэх өргөлт нь өгүүлэх эрхтэний булчингийн чангарал, сулрал, авиаг хэлэхэд гарч буй хийн урсгалын чанга султай нягтан холбоотой. Үгийн өргөлтийг зөв гаргавал авиа балархайших буюу үг идэгдэхээс зайлсхийж чадна. Иймээс үгээ зөв тод, урсам яруу хэлэхийн тусад үгийн зөв өргөлтийг эрхэмлэх нь зүйтэй. Гэхдээ өгүүлбэрийг дан дан үгээр нь биш бүрэн бүтэн утгаар нь өргөлттэй айзамтай уншвал илтгэх гэсэн санаагаа бүрэн төгөлдөр хүргэж чаддаг. Энэ нь нэвтрүүлж хөтлөхөд үгийн өргөлтөөс гадна өгүүлбэрийн өргөлт онцгой чухал үүрэг

гүйцтэгдэг гэснийг харуулж байгаа юм. Өгүүлбэрийн өргөлтийг бас логикийн өргөлт, утгын өргөлт, сэтгэлгээгийн өргөлт гэх мэтчилэн адил бусаар нэрлэдэг. Өгүүлбэр дэх аль нэгэн гишүүн (даан үг, хэлхэц)-г зориуд товойлгон чухалчлах үүднээс чанга тод хэлсэн байвал өгүүлбэрийн өргөлт түүн дээр тусж байна гэсэн үг. Нэвтрүүлэгч буюу уран уншлагад өгүүлбэрийн өргөлтийг зүй зохистой хэрэглэх нь үг өгүүлбэрийн утга санааг зөв оновчтой бөгөөд яруу төгөлдөр илтгэх чухал элемент юм. Хэрвээ тийм биш бол сонин мэдээ, яриа илтгэлийн голдлого тодорхой бус, хүмүүст өгөх утга санаа нь гүнзгий бус болно³. Нэвтрүүлэгчийн нэвтрүүлэг хий үе бол тухайн хүний сэтгэхүй хамгийн хөөрөлтийн үе мөн. Мөн бусад ч хэрэг бодисын тухай тусгал хамгийн хурц соргог үе мөн. Эх бичиг байсан ч үгүй ч, шууд нэвтрүүлэг эсхүл шингээлтэд нэвтрүүлгийн бичлэг аль нь болсон ч болог, цаг хугацаа орон зайд үл захирагдан эрхбиш хурц тусгал, амьдлаг сэтгэхүйтэй байхыг баримтлах ёстой.

Ажиглаж байхад энэ нэвтрүүлэгч “тааруу эх зохиолыг сайн уншиж амилууллаа”, эсвэл нөгөө нэвтрүүлэгч “сайхан эх зохиолыг саар уншиж баллалаа” гэх яриа байнга сонсогддог. Энэ нь нэвтрүүлэгч хөтлөгчийн хариуцлагаас гадна хэл хэллэгээ яаж үзэгч сонсогчид бүрэн зөв бөгөөд айзам хэмнэлтэй, гүн суугдалтай хүргэх бэ гэсэн уран чадварын асуудлыг ярьж байгаа хэрэг. Иймээс нэвтрүүлэгч хөтлөгчийн тэргүүнд хэл авианы дасгалыг сайтар хийхээс гадна амьсгаагаа сайжруулах, зогсолт өргөлтийг зөв шийдвэрлэх зэрэг дадал чадвар, мэдлэг боловсролыг дутуу үнэлж болохгүй юм.

Ишлэл

- ¹ Зулькафиль М. Сэтгүүл зүйн тайлбар толь. 2016. ӨМИС-ийн Хэвлэлийн хороо. х.3.
- ² Хурц. Радио телевизийн хөтлөгчийн ерөнхий хэв боловсролын тухай. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2017. х. 103.
- ³ Баярт. Монгол хэлний нэвтрүүлгийн ухаан. Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо. 2018. х.27-30.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баярт. Монгол хэлний нэвтрүүлгийн ухаан. 2018. Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо.
2. Зулькафиль М. Сэтгүүл зүйн тайлбар толь. 2016. ӨМИС-ийн Хэвлэлийн хороо.
3. Сампилдэндэв Х. Хүүхдийн аман зохиолын учир. 1983. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.
4. Сүхбаатар Ц. Яруу өгүүлэх чадвар. 2012. Үндэстэний Хэвлэлийн хороо.

5. Хурц. Радио телевизийн хөтлөгчийн ерөнхий хэв боловсролын тухай. 2017. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо.
6. Цэвлээ Х. Өвөөгийн жор. 2012. УБ.
7. 美国) 肯·梅茨乐著“创造性的采访”中国人民大学出版社 2012.
8. 周康梁“做最牛的主持人”南方日报出版社 2009.

Резюме

Статья посвящена некоторым практическим и методологическим вопросам мастерства телеведущего и диктора. Автор опираясь на практические примеры ведущих и дикторов телевидения Внутренней Монголии КНР подчеркивает основные недостатки, которые наблюдаются в их работе и предлагает некоторые методические рекомендации, влияющие на устранение этих недостатков.